



**МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53. Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2026.03.17 № 01/902
танай 2026.02.09 -ны № 09 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 09 дугаартай тэтгэврийн нэмэгдлийн талаар ирүүлсэн асуулгад дараах хариуг хүргүүлж байна.

1.Монгол Улсын Засгийн газар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Тэтгэврийн хэмжээг 80,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Монгол Улсын өнөөдрийн инфляцтай уялдаж байгаа эсэх талаар;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ.” гэж заасан.

Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын 2025 оны инфляцын жилийн түвшинг 8.6 хувь гэж зарласан.

Монгол Улсын Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай 478 тэрбум төгрөгийг баталж өгсөн.

Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 242 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, дундаж тэтгэвэр 8.6 хувиар нэмэгдэж 930.2 мянган төгрөгт хүрсэн.

2.Засгийн газар цаашид тэтгэвэр нэмэгдүүлэхтэй холбоотой баримталж байгаа бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөний талаар;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тэтгэврийн хэмжээг жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж нэмэгдүүлнэ.

Нийгмийг даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08

дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө.” гэж заасны дагуу итгэлцүүрийг жил бүр батлуулна. Энэ арга хэмжээний үр дүнд шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээ нь өмнөх онуудад тэтгэврээ тогтоолгон, тэтгэврийн хэмжээгээ нэмэгдүүлсэн тэтгэвэр, авагчийн тэтгэврийн хэмжээтэй ойролцоо тогтоолгох боломжтой болно.

Нийгмийг даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан итгэлцүүрийг хэрэглэхдээ тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 1404.0 мянган төгрөг, мөн өдрөөс хойш 2023 оныг дуустал хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд албан журмын даатгуулагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тооцож байна.

Тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 1404.0 мянган төгрөгөөр хязгаарлаж байгааг өөрчлөх шаардлагатай.

Энэ хязгаарлалтыг өөрчлөхөд шаардагдах зардлыг Нийгмийн даатгалын сангийн 2024, 2025, 2026 онуудын төсөвт суулгуулахаар хүргүүлсэн боловч төсвийн хүндрэлтэй байдлаас болж энэ зардал батлагдаагүй. Уг зардлыг 2027 оны төсвийн хязгаар, 2028, 2029 оны төсөөлөлд тусган хүргүүлэхээр ажиллаж байна.

3.Тэтгэврийн доод хэмжээ манай улсын хувьд нэг сарын хугацаанд амьдралын наад захын хэрэглээг хангах боломжтой эсэх талаар;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд бүрэн тэтгэврийн доод хэмжээ тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байх, хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэврийн доод хэмжээ тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй байхаар тус тус заасан.

Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 1 дүгээр сарын байдлаар олгож байгаа бүрэн тэтгэврийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 97.1 хувьтай, хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэврийн доод хэмжээний 82.4 хувьтай тус тус тэнцүү байна.

2026 оны амьжиргааны доод түвшин бүсүүдээс хамааран сард 519.2- 543.7 мянган төгрөг байгаа бол нийгмийн даатгалын сангаас олгож байгаа хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 652.4 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 769.0 мянган төгрөг буюу амьжиргааны доод түвшингээс өндөр байна.

Тэтгэврийн доод хэмжээг огцом нэмэгдүүлэх нь удаан хугацаанд ажиллах, олон жил шимтгэл төлж өндөр тэтгэвэр авах сэдлийг бууруулж, нийгмийн даатгалын зарчимд нийцэхгүй иргэдийн дунд шударга бус байдлыг бий болгох эрсдэлтэй юм.

4.Бүрэн тэтгэврийн доод хэмжээг 1.5 сая төгрөгт хүргэхэд шаардагдах хугацаа, эсхүл бага тэтгэвэр авагч иргэдийн нийгмийн баталгааг хангаж хүрэхүйц тэтгэврийн түвшинд хүргэх талаар тооцоо, судалгаа байгаа эсэх талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

2026 онд нийт тэтгэвэр авч буй иргэдийн 90.9 хувь нь 1.5 сая төгрөгөөс доош тэтгэвэр авч байна. Тэтгэврийн доод хэмжээг 1.5 сая төгрөг болгоход тэтгэврийн даатгалын санд сард 333.8 тэрбум төгрөг, жилдээ 4.0 их наяд орчим төгрөг нэмж шаардагдахаар байна.

Үүний тулд тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 12.8 пунктээр нэмэгдүүлж 29.8 хувь болгох эсхүл тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасын хэмжээг 4 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай юм.

Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг 2030 он гэхэд 70 хувиар нэмэгдүүлэхээр заасан болно.

Хүндэтгэсэн,



Т.АУБАКИР